


“Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадам” усанд сэлэлтийн тэмцээн



“Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадам”-ын  
усанд сэлэлтийн тэмцээний

# УДИРДАМЖ

2025 оны 5 сарын 30 өдрөөс 6 сарын 01-ний өдөр

Төв бассейн

АГУУЛГА:

|   |    |
|---|----|
| 1. Тэмцээний мэдээлэл.....  | 3  |
| 2. Ерөнхий мэдээлэл.....  | 3  |
| 3. Насны ангиал.....  | 3  |
| 4. Тэмцээний бүртгэл .....  | 3  |
| 5. Буцаалт.....   | 4  |
| 6. Медаль, диплом, цом.....                                       | 4  |
| 7. Тэмцээний байршил.....   | 5  |
| 8. Бие халаалтын заавар.....                                      | 5  |
| 9. Эсэргүүцэл.....  | 6  |
| 10. Тэмцээний төрөл.....  | 6  |
| 11. Тэмцээний хөтөлбөр.....                                       | 7  |
| 12. Тэмцээний хувцас, хэрэглэл, сурталчилгаа .....                | 8  |
| 13. Тэмцээнд оролцогчдын ёс зүйн хэм хэмжээ.....                  | 9  |
| 14. Тамирчны харьялал, байгууллага клубыг төлөөлөх эрх .....      | 9  |
| 15. Тэмцээнд оролцогч хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын журам ..... | 10 |
| 16. Тамирчны хувийн аюулгүй байдал, хариуцлагын журам .....       | 13 |

Founded  
1991

ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО

Ерөнхий Нарийн Бичгийн дарга  
Шүүгчдийн Зөвлөлийн гишүүн  
Техникийн багийн ахлагч

/М.Энхбаатар/  
/Д.Тэмүүлэн/  
/Б.Шинэбаяр/

МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО

**1. ТЭМЦЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Тэмцээн: “Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадам”-ын усанд сэлэлтийн тэмцээн

Эхлэх он, сар, өдөр: 2025 оны 05 сарын 30 өдөр

Дусах он, сар, өдөр: 2025 оны 06 сарын 01 өдөр

| Он сар өдөр         | Гараг  | Цагийн хуваарь |       |
|---------------------|--------|----------------|-------|
|                     |        | Финал          | Финал |
| 2025 / 05 / 30 өдөр | Баасан | 09:00          | 16:00 |
| 2025 / 05 / 31 өдөр | Бямба  | 09:00          | 18:00 |
| 2025 / 06 / 01 өдөр | Ням    | 09:00          | 18:00 |

Байршил:

**2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

- 2.1. “Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадам”-ын усанд сэлэлтийн тэмцээн нь “МУССХ-ны Тэмцээний дүрэм”-ийн дагуу явагдана.
- 2.2. Тэмцээнийг ганцаарчилсан болон буухиа төрлөөр зохион байгуулна.

**3. НАСНЫ АНГИЛАЛ**

- 3.1 Насны бүлэг: 15-17 нас
- 3.2 Насны бүлгийг 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тооцно
- 3.3 Тамирчид зөвхөн өөрийн насны бүлэгт өрсөлдөнө
- 3.4 Зохион байгуулагчид тамирчны бичиг баримтыг шаардаж, насны бүлгийг баталгаажуулан шалгах эрхтэй бөгөөд зөрчил гарсан тохиолдолд тэмцээнээс хасах арга хэмжээг авч, Ёс зүйн зөвлөлд шилжүүлэн хариуцлага тооцуулна.

| Насны бүлэг | Төрсөн он |
|-------------|-----------|
| 15-17       | 2008-2010 |

**4. ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ**

- 4.1. Тэмцээний бүртгэлийг аймаг, дүүргийн Биеийн тамир спортын хороогоор дамжуулан хийнэ. Тамирчдын оролцох зайд төрлийн мэдүүлэг 2025 оны 05 сарын 23:59 цагт хаагдана.
- 4.2. Харьяа аймаг дүүргийн урьдчилсан шатны шалгаруулалтад оролцож эрхээавсан, оролцох зайд төрлийн мэдүүлгээ тогтоосон хугацаанд гаргасан бүх тамирчид тэмцээнд оролцох эрхтэй.
- 4.3. Техникийн зөвлөгөөнд бүх багийн ахлагчид оролцох үүрэгтэй. Хүндэтгэх шалтгаангүйгээр оролцоогүй ахлагчид 100'000 төгрөгийн тортогууль ноогдуулна.
- 4.4. Тэмцээнд оролцогчдын гарааны дараалал, хуваарийг тэмцээн эхлэхээс 5 хоногийн өмнө нийтэлнэ.
- 4.5. Багийн ахлагч нар гарааны хуваарь гарсны дараа өөрийн багийн тамирчдын бүртгэлийг нягтлан шалгаж, ямар нэг алдаа гарсан байвал яаралтай зохион байгуулагчдад мэдэгдэх үүрэгтэй.
- 4.6. Тамирчид тэмцээнд оролцохын өмнө хувийн аюулгүй байдал, хариуцлагын журам, заавартай танилцаж гарын үсэг зурснаар тэмцээнд оролцох эрх эцсийн байдлаар нээгдэнэ /12 дугаар хуудас, хэвлэж гарын үсэг зурах/. Багийн ахлагчид эх хувийг хураан авсан байна.
- 4.7. Тэмцээнд оролцогч хүүхэд нэг бүрийг эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна.

## 5. БУЦААЛТ

- 5.1. Эрүүл мэндийн шалтгаанаас бусад тохиолдолд тамирчин гараанд гараагүй бол тамирчныг 50,000 төгрөгөөр тортогоно.
- 5.2. Эрүүл мэндийн шалтгаанаар гараанд гараагүй тамирчин тухайн өдрийн дараагийн гараануудад оролцох эрхгүй.
- 5.3. Багийн ахлагч гараанд гараагүй тамирчны маягтыг бөглөж, эрүүл мэндийн магадлагааны хамт гараа эхлэхээс 30 минутаас багагүй хугацааны өмнө Ерөнхий шүүгчид хургуулсэн байна.
- 5.4. Тэмцээнийг зохион байгуулагчдын буруутай үйлдлээс болж баг/тамирчин ямар нэг алдаа гаргаж шийтгэл хүлээсэн нь тогтоогдвол баг/тамирчны шийтгэлийг нэн даруй хүчингүй болгож амжилтыг сэргээж, цаашид тэмцээнээ үргэлжлүүлэх боломжоор хангана.

## 6. МЕДАЛЬ, ДИПЛОМ, ЦОМ

- 6.1. “Монголын хүүхдийн спортын зуны VIII наадамд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчдад Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт “Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ын 2.1 дэх заалтаар алтан медаль 600 мянга, мөнгөн медаль 400 мянга, хүрэл медалийг 200 мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал олгоно.
- 6.2. Ганцаарчилсан болон буухиа уралдааны эхний гурван байранд орсон тамирчдад Алт, Мөнгө, Хүрэл медаль, диплом, мөнгөн шагнал
- 6.3. Тамирчид ижил цагийн амжилт үзүүлсэн бол медалийг доорхи байдлаар олгоно

Нэгдүгээр байрны тамирчдын цаг ижил бол:

2 Алт                    Мөнгө байхгүй                    1 Хүрэл

Хоёрдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт                    2 Мөнгө                            Хүрэл байхгүй

Гуравдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт                    1 Мөнгө                            2 Хүрэл

Хэрэв гурван (3) тамирчин ижил цагийн амжилт гаргасан бол медалийг доорхи байдлаар олгоно

Нэгдүгээр байрны тамирчдын цаг ижил бол:

3 Алт                    Мөнгө байхгүй                    Хүрэл байхгүй

Хоёрдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт                    3 Мөнгө                            Хүрэл байхгүй

Гуравдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт                    1 Мөнгө                            3 Хүрэл


## 7. ТЭМЦЭЭНИЙ БАЙРШИЛ

7.1. Төв, Холбогдох утас: 88131777

## 8. БИЕ ХАЛААЛТЫН ЗААВАР

- 8.1. Тэмцээн эхлэхээс 90 минутын өмнө тамирчдын бие халаалт эхлэнэ.
- 8.2. Бие халаалтын журмын биелэлтийг Ерөнхий шүүгч хянаж ажиллана.
- 8.3. Баг тамирчид зөвхөн зохион байгуулагчдын гаргасан хуваарийн дагуу халаалтаа хийх бөгөөд багийн ахлагчид хяналт тавих үүрэгтэй.
- 8.4. Тамирчид бассейны ирмэг дээр суусан байрлалаас хөлөөрөө ус руу орно. Ус руу үсэрч орохыг хатуу хориглоно
- 8.5. Бие халаалтын үндсэн замуудыг доорхи зурагт үзүүлсний дагуу тойрог хэлбэрээр хоёр чиглэлд сэлэхэд ашиглах бөгөөд тус замд шумбалт хийхийг хориглоно.

- 8.6. Хурдтай сэлэлтийн болон араар даллах сэлэлтийн замыг зөвхөн нэг чиглэлд ашиглах бөгөөд зөвхөн энэ замд шумбалт хийхийг зөвшөөрнө.
- 8.7. Бие халалтын үед сэлүүр ашиглахыг хориглоно.
- 8.8. Дасгалжуулагчид бие халаалтын журам болон аюулгүй байдлын зааварчилгааг тамирчиддаа өгөх үүрэгтэй бөгөөд бие халаалтын үеэр байнга хамт байж аюулгүй байдалд нь хяналт тавина. Бусад багуудын халаалтын цаг болоход тамирчдаа бассейнаас даруй гаргах үүрэгтэй.
- 8.9. Автомат цагийн мэдрэгч хавтан суурьлуулсан талаар бассейнаас гарах тамирчид зөвхөн хажуу талын хананы дагуу үсан сангаас гарна.
- 8.10. Бие халаалтын журам зөрчсөн тамирчныг Ерөнхий шүүгч болон тэмцээний зохион байгуулагчид бассейнаас нэн даруй гаргана
- 8.11. Тэмцээн эхлэхээс 15 минутын өмнө бассейныг чөлөөлнө



## 9. ЭСЭРГҮҮЦЭЛ

- 9.1. Эсэргүүцэл илэрхийлэх боломжтой.
- 9.2. Эсэргүүцлийг доорхи тохиолдолд гаргаж болно.
- а. Тэмцээний дүрэм, зохион байгуулах журам тодорхой биш
  - б. Тамирчдад ямар нэг эрсдэл үүссэн бол
  - в. Шүүгчийн шийдвэрийг эсэргүүцэж болно. Гэвч баримтад тулгуурласан шийдвэрийг эсэргүүцэхийг хориглоно.
- 9.3. Эсэргүүцэл мэдүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:
- а. Ерөнхий шүүгчид мэдүүлэх
  - б. Холбооноос боловсруулсан маягтан дээр эсэргүүцлийг бичсэн байх
  - в. Багийн ахлагч мэдүүлгийг бөглөх
  - г. 50,000 төгрөгийн хураамж төлсөн байх (МУССХ-ны дансанд, шилжүүлгийн баримтыг үзүүлэх)
  - д. Тухайн уралдаан болсноос хойш 30 минутын дотор
- 9.4. Дүрмийн дагуу мэдүүлсэн эсэргүүцлийг дараагийн үйл ажиллагаа болон тэмцээний гараа эхлэхээс өмнө шийдвэрлэнэ.
- 9.5. Бүх эсэргүүцлийг Ерөнхий шүүгч хянаж шийдвэрлэнэ. Ерөнхий шүүгч эсэргүүцлийг хүлээж авахгүй байх шийдвэр гаргасан бол шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.

**“Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадам” усанд сэлэлтийн тэмцээн**

9.6. Эсэргүүцлийг хүлээж авахгүй байх шийдвэр гарсан бол 9.3 заасан хураамжийг буцаан олгохгүй. Эсэргүүцлийг хүлээн авсан бол хураамжийг буцааж олгоно.

**10. ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ**

|                            | ЭРЭГТЭЙ /15-17 нас/ | ЭМЭГТЭЙ /15-17 нас/ |
|----------------------------|---------------------|---------------------|
| 100м Өвөр                  | +                   | +                   |
| 200м Өвөр                  | +                   | +                   |
| 100м Ар                    | +                   | +                   |
| 200м Ар                    | +                   | +                   |
| 100м Мэлхий                | +                   | +                   |
| 200м Мэлхий                | +                   | +                   |
| 100м Далайн гахай          | +                   | +                   |
| 200м Далайн гахай          | +                   | +                   |
| Буухиа 4 X 100 Өвөр        | +                   | +                   |
| MIX Буухиа 4 X 100 ХОЛИМОГ | +                   |                     |

**11. ТЭМЦЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

**2025 ОНЫ 05 САРЫН 30-НЫ ӨДӨР**

**09:00 ЦАГ**

| № | Зай  | Төрөл                         | Нас   | Гараа            |
|---|------|-------------------------------|-------|------------------|
| 1 | 100м | Өврөөр даллах сэлэлт /эм, эр/ | 15-17 | Урьдчилсан гараа |
| 2 | 200м | Мэлхий сэлэлт/эм, эр/         | 15-17 | Урьдчилсан гараа |
| 3 | 100м | Араар даллах сэлэлт/эм, эр/   | 15-17 | Урьдчилсан гараа |

**16:00 ЦАГ**

| № | Зай  | Төрөл                             | Нас   | Гараа |
|---|------|-----------------------------------|-------|-------|
| 1 | 100м | Өврөөр даллах сэлэлт /эм, эр/     | 15-17 | Финал |
| 2 | 200м | Мэлхий сэлэлт/эм, эр/             | 15-17 | Финал |
| 3 | 100м | Араар даллах сэлэлт/эм, эр/       | 15-17 | Финал |
| 4 | 100м | 4x 100м Буухиа өврөөр даллах /эм/ | 15-17 | Финал |

**2025 ОНЫ 05 САРЫН 31-НИЙ ӨДӨР**

**09:00 ЦАГ**

| № | Зай  | Төрөл                        | Нас   | Гараа            |
|---|------|------------------------------|-------|------------------|
| 1 | 200м | Араар даллах сэлэлт /эм, эр/ | 15-17 | Урьдчилсан гараа |
| 2 | 100м | Эрвээхий сэлэлт /эм, эр/     | 15-17 | Урьдчилсан гараа |
| 3 | 200м | Өврөөр даллах сэлэлт/эм, эр/ | 15-17 | Урьдчилсан гараа |

**18:00 ЦАГ**

| № | Зай  | Төрөл                              | Нас   | Гараа |
|---|------|------------------------------------|-------|-------|
| 1 | 200м | Араар даллах сэлэлт /эм, эр/       | 15-17 | Финал |
| 2 | 100м | Эрвээхий сэлэлт /эм, эр/           | 15-17 | Финал |
| 3 | 200м | Өврөөр даллах сэлэлт/эм, эр/       | 15-17 | Финал |
| 4 | 100м | 4 x 100м Буухиа өврөөр даллах /эм/ | 15-17 | Финал |

**2025 ОНЫ 06 САРЫН 01-НИЙ ӨДӨР**

**09:00 ЦАГ**

## “Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадам” усанд сэлэлтийн тэмцээн

| №         | Зай  | Төрөл                        | Нас   | Гараа            |
|-----------|------|------------------------------|-------|------------------|
| 1         | 100м | Мэлхий сэлэлт /эм,эр/        | 15-17 | Урьдчилсан гараа |
| 2         | 200м | Эрвээхий сэлэлт /эм, эр/     | 15-17 | Урьдчилсан гараа |
| 18:00 ЦАГ |      |                              |       |                  |
| №         | Зай  | Төрөл                        | Нас   | Гараа            |
| 1         | 100м | Мэлхий сэлэлт /эм,эр/        | 15-17 | Финал            |
| 2         | 200м | Эрвээхий сэлэлт /эм, эр/     | 15-17 | Финал            |
| 3         | 100м | MIX Буухиа 4 x 100 м Холимог | 15-17 | Финал            |

### 12. ТЭМЦЭЭНИЙ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА

12.1 Усанд сэлэлтийн тэмцээний эрэгтэй усны хувцасны дээд хэсэг хүйснээс дээш, доод хэсэг өвдөгнөөс доош байж болохгүй. Эмэгтэйчүүдийн хувьд усны хувцас нь хүзүүг халхалж, дээд хэсэг мөрнөөс дээш, доод хэсэг өвдөгнөөс доош байж болохгүй. Усны хувцас нь нэхмэл материалаар хийгдсэн байх ёстой.

12.2 Усны өмсгөлийн өнгө тунгалаг/гэрэлтэж харагддаг байж болохгүй. 2 \Хоёр\ давхар малгай өмсч болно.

12.3 Тамирчны малгай, шил нь усан сэлэлтийн төрөлд тохирсон байх бөгөөд ямар нэгэн сөрөг сэтгэгдэл төрүүлэх тэмдэг, тэмдэглэгээгүй байна.

12.4 Тэмцээний үеэр тамирчин хурд, хөвөх чадвар, тэсвэр хатуужилд нь туслах ямар нэгэн төхөөрөмж, усны хувцас ашиглахыг хориглоно.

12.5 Гэмтлийн улмаас хоёроос илүүгүй хөлийн хурууг нааж болно. Ерөнхий шүүгч зөвшөөрснөөс бусад тохиолдолд тамирчин бие дээрээ ямар нэг наалт наахыг хориглоно.

12.6 Өсвөр үе, залуучуудын насны бүлгийн рекорд амжилтыг зөвшөөрөгдсөн усан сэлэлтийн хувцас хэрэглэсэн тохиолдолд л МУССХ хүлээн зөвшөөрнө.

12.7 Тамирчид тэмцээний нээлт, хаалт, шагнал гардуулах ёслолын үеэр багийн бэлтгэлийн хувцаар жигдэрсэн байна.

12.8 Тамхи болон согтууруулах ундааны сурталчилгааг хориглоно

12.9 Бие дээрх ямар нэг таних тэмдэг, сурталчилгааг хориглоно

12.10 Тамирчны харьяалагдах байгууллага, клубын нэр болон таних тэмдгийг зар сурталчилгаанд тооцохгүй.

12.11 Энэхүү дүрмийн ерөнхий шаардлагыг илт зөрчсөн хувцас хэрэглэлтэй тамирчинд Ерөнхий шүүгч зөрчлийг арилгах шаардлага тавих бөгөөд шаардлагыг биелүүлээгүй бол тэмцээнээс хасах эрхтэй.

### 13. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЁС ЗҮЙН ХЭМ, ХЭМЖЭЭ

13.1 Тэмцээнд оролцогч тамирчид, дасгалжуулагчид, баг хамт олон, эцэг эхчүүд болон хөгжөөн дэмжигчид доорхи ёс зүйн хэм хэмжээг баримтлана. Үүнд:

13.2 Үнэнч шударгаар өрсөлдөж, ёс зүйн аливаа зөрчил гаргахаас зайлсхийх

13.3 Усан спортыг гутаан доромжлох, усан спорт болон МУССХ-ны нэр хүндийг унагаах үйлдэл/ эс үйлдэл хийхэс зайлсхийх

13.4 Тэмцээнийг зохион байгуулагчид болон бусад тамирчид, хэвлэл мэдээлэл болон үзэгчдийн эсрэг заналхийлсэн, хүчирхийлсэн, үл хүндэтгэсэн зан авир гаргахгүй байх.

13.5 Бусдыг үндэс угсаа, арьсны өнгө, нас хүйс, шашин шүтлэг, хэл соёл, хувийн үзэл бодол, өмч хөрөнгө, хөгжлийн бэрхшээл болон бусад бүх үндэслэлээр ялгаварлан гадуурхахаас зайлсхийх.

13.6 Тэмцээний үйл ажиллагаа, зохион байгуулалтад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, тогтоосон дэгийг зөрчихгүй байх. Энэ заалт нь усан сангийн бүх хэсэг болон тухайн арга хэмжээний гадна талбайд болсон зөрчилд ч хамаарна.

13.7 Тэмцээний бүхий л үйл ажиллагаа буюу нээлт , хаалт, шагнал гардуулах ёслолд идэвхтэй оролцох.

13.8 Сэргээшийн эсрэг хөтөлбөрийг дэмжиж, дэлхийн сэргээшийн эсрэг дүрмээр хориглосон ямар нэг бэлдмэл, зан үйлийг ашиглахгүй байх

13.9 Согтууруулах ундаа, утаат болон цахилгаан тамхи (vape) хэрэглэхийг хатуу хориглоно. Энэ заалт нь усан сангийн бүх хэсэг болон тухайн арга хэмжээний гадна талбайд болсон зөрчилд ч хамаарна.

13.10 Тамирчдын насыг санаатайгаар буруу мэдээлэх, холбогдох баримтыг засварлах, хуурамчаар үйлдэхгүй байх.

13.11 Эдгээр ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл/эс үйлдлийг тэмцээнийг зохион байгуулах хороонд мэдэгдэж хамтран ажиллах

#### 14. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧ ХҮҮХДИЙН ЭРХ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЖУРАМ

14.1 Тэмцээнийг зохион байгуулагчид болон оролцогч бүх талууд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын дараах зарчмуудыг баримтална.

- хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих;
- хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;
- хүүхдийн язгуур эрх ашгийг хүндэтгэн, хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах;
- хүүхдийн нас, бие сэтгэхүй, төлөвшлийн байдлыг харгалzan, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
- Тэмцээний үйл ажиллагаа нь улс төрийн нам, \хувь хүн болон хуулийн этгээдийн ашиг сонирхлоос ангид байх;
- хүүхдийн, бие физиологийн онцлог, хувийн нууцыг хадгалах, нэр төрийг эрхэмлэх;

14.2 Тэмцээнийг зохион байгуулагч нь доорхи зүйлсийг эрхэмлэн ажиллана.

- Тэмцээний бүхий л үйл ажиллагаа нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжихэд чиглэх;
- Хүүхдийг үл хайхрах явдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлж, учирч болзошгүй хор нөлөө, сөрөг үр дагаврыг анхаарч, бүх орчинд хүүхдийн эрхийг ханган ажиллах;
- Онцгой халамж, анхаарал шаардах хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оролцох боломжийг бүрдүүлж, тусгай хэрэгцээг ханган ажиллах;
- Угсаатан болон хэлний цөөнх, нутгийн уугуул иргэдэд харьяалагдах хүүхдийг тэмцээнд оролцох нөхцлийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх;
- Тэмцээний үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй удирдамж боловсруулж, үйл ажиллагаа болох газар, үргэлжлэх хугацаа, бэлтгэх зүйлс, хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой тусгаж, оролцогч талуудад танилцуулах;
- Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн үйл ажиллагаанд ашиглаж буй техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах;
- Эрүүл мэндийн тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

14.3 Тэмцээнд тамирчдаа оролцуулж буй байгууллага, клубууд доорхи үүрэгтэй

- Тамирчдаа шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, биеийн онцлог, эрүүл мэндийн нөхцөл байдалд тохирсон бэлтгэл сургуулилт хийлгэх, ачааллыг тэнцвэржүүлэх;
- Багш, дасгалжуулагчид хүүхэд хамгааллын сургалтад хамрагдсан байх;
- Хүүхдийн бэлтгэл сургуулилт хийх хугацаа 7 хоногт 30 цагаас илүүгүй байх;

## **"Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадам" усанд сэлэлтийн тэмцээн**

- Эрүүл мэндийн болон хүндэтгэх шалтгааны үлмаас төлөвлөсөн үйл ажиллагаанд оролцох боломжгүй тохиолдолд багш, дасгалжуулагч, эцэг эх болон бусад оролцогч талуудын зүгээс хүүхдийн гаргасан шийдвэрийг хүндэтгэх;
- Тамирчныг хариуцагч этгээд, багш, дасгалжуулагч нь хүүхдийн эрүүл мэнд, бие физиологийн талаар нарийвчилсан мэдээллийг эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс авч, яаралтай тохиолдолд хариу арга хэмжээ авах;
- Тэмцээнд оролцогч хүүхэд нэг бүрийг эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулах;

### **14.4 Тамирчин хүүхдийн эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх/үүрэг**

- Эцэг эх харгалзан дэмжигч нь хүүхдийн эрхийг хүндэтгэн, хүүхдийнхээ хүсэл, сонирхлыг харгалзан, нас, бие бялдар, сэтгэхүйн онцлогт тохирсон үйл ажиллагаанд оролцуулах эрхтэй;
- Зохион байгуулагч болон оролцуулагч этгээдээс тухайн арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсны дараа хүүхдийг оролцуулах эсэхийг тухайн хүүхэдтэй зөвшилцэж шийдвэр гаргах, бичгээр зөвшөөрөл өгөх үүрэгтэй;
- Хүүхдээ эрүүл мэндийн байдлыг, зохион байгуулагч болон оролцуулагч талуудад үнэн зөв мэдээлэх үүрэгтэй;
- Хүүхэд нь тээвэрлэх үед жолооч болон зохион байгуулагч, багш, эцэг эх, дасгалжуулагчийн зааврыг дагаж мөрдөх үүрэгтэй.

- Тээврийн хэрэгсэлд орж, гар тээшээ зориулалтын газар байрлуулан, суудалдаа сууж, хамгаалах бүсээ зүүх, тээврийн хэрэгслийн цонхоор цухуйх, хөдөлгөөн хийж байх үед суудлаасаа босох үйлдлийг хийхгүй байхыг хүүхэддээ анхааруулан сануулсан байх үүрэгтэй;

### **14.5 Тамирчин хүүхдийн суурь боловсрол эзэмших эрх зөрчигдөхгүй байхад анхаарч сургууль, багш, дасгалжуулагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн хичээл сургалтыг тасалдуулахгүй байх чиглэлээр хамтран ажиллаж болно. Үүнд:**

- Хичээл сургалтын үйл ажиллагааг нөхөх зорилгоор давтлага өгөх, зайнаас суралцах нөхцөл боломжийг бүрдүүлэх;
- Хоцрогдолыг арилгах, хичээл нөхөх боломжийг бүрдүүлэхдээ хүүхдийн өдрийн хичээл сургалтын цагийн ачааллыг хэтрүүлэхгүй байх;
- Сургууль, багш, дасгалжуулагч, гишүүн байгууллага, клубын ажлын амжилтыг чухалчлан суралцагчийг тэмцээнд оролцуулах эсхүл албадлага үзүүлэх зэргээр хүүхдийн эрхийг зөрчихгүй байх;

### **14.6.Тэмцээний үйл ажиллагаанд оролцогч бүх талууд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар доорхи чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:**

- Хүүхдийг энэхүү тэмцээнд оролцуулахдаа хүүхдийн өөрийн хүсэл, сонирхол, оролцох эсэх талаар шийдвэрийн үндсэн дээр эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл авч оролцуулах бөгөөд тухайн арга хэмжээний хамрах хүрээ, хугацаа, байршил зэргээс хамааран бичгээр зөвшөөрөл авч оролцуулах;
- Хүүхдийг өөрийн оршин суугаа газраас өөр хот, суурин газарт тэмцээнд оролцуулж байгаа бол эрүүл ахуйн болон аюулгүй байдлыг хангасан байрлах байрыг урьдчилан бэлтгэсэн байх;
- Хүүхдийг оролцуулахаар шийдвэр гаргасан тохиолдолд хүүхдийн оролцоо, хүүхдэд олгох урамшуулал, оролцох зардлыг зохицуулах
- Тамирчдыг байрлуулах байрыг эрэгтэй, эмэгтэй хүүхдийг тус тусдаа байрлахаар зохион байгуулах;
- Тамирчин хүүхэд байрлаж буй байранд архидан согтуурах, хүчирхийлэл үйлдэх зэрэг зүй бус үйлдэл гаргахгүй, дээрх нөхцөл байдал үүсвэл тухайн байр, буудлын зохион байгуулагчид мэдэгдэж даруй арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх;
- Хүүхдийн эрүүл мэнд хохирох, бэлгийн дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлэх;

## **"Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадам" усанд сэлэлтийн тэмцээн**

- Бага насны буюу 6-9 хүртэлх насны хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчийн хамт, эсвэл эцэг эх, асран хамгаалагч бичгээр зөвшөөрсний дагуу багш, дасгалжуулагчид, 10-18 хүртэлх насны хүүхдийг эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэй авч явах;
- Тамирчин хүүхдийг өдөрт хэт олон гараанд оролцуулахгүй байх;
- Хүүхдийг уралдаан, тэмцээнд оролцуулахдаа удирдсан багшаас гадна эрүүл мэндийг хариуцах эмч/эсвэл энэ чиглэлийн мэдлэг боловсролтой хүнийг томилон ажиллуулах;
- Хүүхдийн дэргэд архи тамхи, мансууруулах бодис хэрэглэх, хууль бус үйлдэл мөрийтэй тоглоом, мөрийцэх зэрэг ёс бус үйлдэл гаргахгүй зүй бус хэллэг хэрэглэхгүй байх;
- Тамирчин хүүхдийн нэр хүндэд нөлөөлөх, эсвэл хүүхэд эмзэглэх зураг, дуу дүрс бичлэгийг зөвшөөрөлгүй бичих, бусдад дамжуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тавихгүй байх;
- Тэмцээний үеэр хүүхэдтэй хүндэтгэлтэй харьцах, биеийн төрх, үйлдлээрээ айлан сүрдүүлэхгүй, үл хайхрах, хүүхдийг гутаах, доромжлох, нэр хоч өгөх, хүүхдийн уралдаан тэмцээнд гаргасан амжилт буурсан тохиолдолд сэтгэл санааны дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- Аливаа улс төрийн үйл ажиллагаа, жагсаал цуглаанд хүүхдийг оролцуулахгүй байх;
- Тэмцээнд оролцогч хүүхэдтэй хувийн харилцаа үүсгэх, зөвшөөрөгдөх бүсээс авч гарахгүй байх;

14.7 Хүүхдийг өөрийн оршин суугаа газраас өөр хот, суурин газарт тэмцээнд оролцуулж байгаа бол хүүхэд тээвэрлэх үйл ажиллагаанд доорхи зүйлсийг анхааран ажиллана.

- Хүүхдийг тээвэрлэхдээ Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийг мөрдлөг болгоно.
  - Улс, аймаг, бүсийн чанартай тэмцээн, уралдаанд хүүхдийг оролцуулахдаа хүн тээврийн зориулалт бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэх, аюулгүй байдлыг хангах;
  - Хүүхдийг аливаа арга хэмжээнд оролцуулахаар хүүхдийг тээвэрлэхдээ цаг агаарын нөхцөл байдлыг харгалзах, жолооч нь ажил амралтын гормыг мөрдөх;
  - Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598 стандартын 8-р зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан байх;
  - Тээврийн жолооч нь хүүхдийг тээвэрлэхээс өмнө зориулалтын суудалд суулгаж, хамгаалах бүс бүслэх, хөдөлгөөн эхэлснээс хойш босож явахгүй байх талаар зөвлөгөө өгөх;
  - "Хүүхэд тээвэрлэж байна" анхааруулгын тэмдэг наасан байна.
  - Хүүхдийг хариуцагч багш, эцэг эх, дасгалжуулагч нь хүүхдэд тээврийн хэрэгсэл зогсох, хөдөлгөөнд оролцох үед аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар зааварчилгаа өгч, тэдний аюулгүй байдлыг ханган ажиллана.
  - Хүүхэд тээвэрлэх жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, замын хуудас зэргийг биедээ авч явах;
  - Жолооч нь суудлын тооноос илүү хүүхэд тээвэрлэх, зорчигчийн танхимд хүүхэд байх үед автобусыг эзэнгүй орхих, хөдөлгөөний үед огцом тооромслох, тамхи татах зэргийг хориглоно;
  - Хүүхэд тээвэрлэх явцад техникийн эвдрэл саатал гарсан үед яаралтай холбогдох байгууллагад мэдэгдэж, дараагийн автобус иртэл хүүхдийн аюулгүй байдлыг хангах;
  - Хүүхдийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулах ба тээвэрлэгч нь гэрээгээр тогтоосон замнал болон цагийн хуваарийн дагуу хүүхдийн аюулгүй байдлыг ханган тээвэрлэх;
- Хүүхдууд доорхи үүргийг хүлээнэ. Үүнд:
- Хүүхэд нь жолооч болон зохион байгуулагч, багш, эцэг эх, дасгалжуулагчийн зааврыг мөрдөх;
  - Тээврийн хэрэгсэлд орж, гар тээшээ зориулалтын газар байрлуулан, суудалдаа сууж, хамгаалах бүсээ зүүх;
  - Тээврийн хэрэгслийн цонхоор цухуйх, хөдөлгөөн хийж байх үед суудлаасаа босох үйлдлийг хийхгүй байх;

ТАМИРЧНЫ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ЗӨВШӨӨРӨЛ БУЮУ  
ХУВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАРИУЦЛАГЫН ЖУРАМ

Миний бие ..... овогтой ..... нь /РД: ..... / өөрийн хүү/охин (зурах) ..... овогтой ..... -ыг “Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадам”-ын усанд сэлэлтийн тэмцээнд оролцохыг зөвшөөрч байгаа бөгөөд Хувийн аюулгүй байдал, хариуцлагын энэхүү журамтай танилцсан болно. Тэмцээнд оролцох үед гарч болох аливаа эрсдлийг өөрийн биеэр хариуцах болно.

1. Тэмцээнд оролцох төрөл, зайдaa сайтар бэлтгэгдсэн байх. Өөрийн үр чадвар болон бие бялдрын чадавхид тохирсон төрөл зайдaa өрсөлдөх.
2. Тэмцээний үеэр бассейны болон угаалгын өрөөний гулгамхай гадаргуу, шалан дээр хальтрах, үсрэлтийн тавцан дээрээс унаж бэртэхээс сэргийлэх.
3. Тэмцээний үеэр (тэмцээний өмнөх болон дарагийн өдөр хамаарна) хүний биеийг сэргээх үйлчилгээ бүхий хүнсний болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэхгүй байх. Үүнд: кофе, энергийн үндаа, бусад хүч тамир сэргээх бэлдмэлүүд гэх мэт.
4. Биеийн байдлын маш бага зэргийн өөрчлөлтийн үед ч тэмцээнд оролцох болон гараанд гарахаас татгалзах. Үүнд: даралт ихсэх болон багасах, зүрхний цохилт олон болон цөөн болох, халуурч бүлээрэх, амьсгал бачуурах, харшлын шинж тэмдэг гэх мэт.
5. Тэмцээний Удирдамж, МУССХ-ны Тэмцээний дүрэм болон Ёс зүйн дүрэмтэй танилцаж, Зохион байгуулагчид болон Шүүгчдийн шийдвэрт хүндэтгэлтэй хандаж, тогтоосон дүрэм журмыг чанд сахих.
6. Ямар ч үед зөвхөн өөрийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг дээдэлж шийдвэр гаргах. Энэхүү шийдвэрийг гаргахдаа бусдын нөлөө, ятгалганд үл автах.
7. Тэмцээнийг зохион байгуулагчдын хувьд тамирчдын эрүүл мэнд, аюулгүй байдал хамгийн эрхэм зүйл гэдгийг хүлээн зөвшөөрч, энэхүү журмыг хүндэтгэн биелүүлэх.

Журамтай танилцаж зөвшөөрсөн:

.....  
/Тамирчин эсвэл эцэг эхийн нэр, гарын үсэг/  
Огноо: 2025 / \_\_\_\_ / \_\_\_\_ өдөр

Тамирчны оролцох төрөл зайдaa сайтар бэлтгэгдснийг баталсан:

.....  
/Дасгалжуулагчийн нэр, гарын үсэг/  
Огноо: 2025 / \_\_\_\_ / \_\_\_\_ өдөр

/хэвлэж гарын үсэг зураад зохион байгуулагчдад хураалгаснаар тэмцээнд оролцох эрх нээгдэнэ/